



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/2025 оны жилийн эцсийн байдлаар/

УЛААНБААТАР ХОТ
2025 он

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан Сайдын эрхлэх асуудлын хүрээний арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгснөөр дээд шатны удирдлагыг бодит мэдээллээр ханган цаашид салбарын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж гарган дэмжлэг үзүүлэх зорилгоор үнэлгээний ажлыг зохион байгуулав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгон, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлалын салбар, залуучуудын хөгжлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хөтөлбөрийн болон төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн холбогдох нотлох баримт материал судалгаанд үндэслэн, асуудал хариуцсан нэгжээс тайлбар, нэмэлт тодруулга авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулан бататгаж, удирдлага, зохион байгуулалтын болон оролцогч талуудын хамтын ажиллагаа зэргийг харгалзан журмын 6.1-т заасан үнэлгээний аргазүйг ашиглан үнэллээ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

3.1 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт:

Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2025 онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээнд шаардагдах төсөв хөрөнгийг 2025 оны улсын төсөвт тусгасан байдалд дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хангах 2 зорилт, 5 дэд зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 9,300.0 сая төгрөг;
- Хүний хөгжлийн бодлогыг хангах 1 зорилт, 3 дэд зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 127,637.3 сая төгрөг;
- Эдийн засгийн бодлогыг хангах 2 зорилт, 4 дэд зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 161,114.0 сая төгрөг;
- Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогыг хангах 1 зорилт 2 дэд зорилтын хүрээнд 6 арга хэмжээ хэрэгжүүлэхэд 2,200.0 сая төгрөг;

нийт 89 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхэд 300,215.3 сая төгрөг шаардагдахаар төсөвлөсөн боловч 2025 оны улсын төсөвт 3 арга хэмжээнд 34,688.7 сая төгрөгийн хөрөнгө батлагдсан байна.

Энэ нь Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад ССАЖЗ-ын Сайдын багцад 50 төсөл, арга

хэмжээнд 145,245.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсан дүнтэй харьцуулахад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлттэй уялдаагүй байна.

“Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6-д заасан аргачлалын дагуу ССАЖЗЯ-ны ХШҮДАГ-ын хяналтад байгаа 89 арга хэмжээнд яамны газар, хэлтсүүдийн өөрсдийн өгсөн үнэлгээг нягтлан, нотлох баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ хийж үнэлсэн. Тодруулбал: ССАЖЗЯ-ны хэрэгжүүлэх үндсэн 83 арга хэмжээ, бусад 4 яамтай хамтран хэрэгжүүлэх 6 арга хэмжээ байна.

Үнэлгээний үр дүн:

№	Үзүүлэлт	Үнэлгээ					Нийт	
		85-100%	60-84%	30-59%	0-29%	ХБ	Заалтын тоо	Дундаж үнэлгээ
1	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын үнэлгээ	44	9	10	19	1	83	66.5

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 1 арга хэмжээ, 0-29 хувьтай үр дүн гараагүй 19 арга хэмжээ, 30-59 хувьтай үр дүн хангалтгүй 10 арга хэмжээ үнэлэгдсэн бөгөөд цаашид төсөл арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

Тайлант хугацаанд хэрэгжилтийн үр дүн гараагүй буюу 0-29%-ийн хэрэгжилттэй 19 арга хэмжээний жагсаалт. Үүнд:

Зорилго	Дэд зорилт	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэл ийн хувь
1.2.2. Улсын зэрэглэлтэй болон дагуул хотуудын хөгжил	1.2.2.4. Хөшигийн хөндийд шинээр бий болох сургалт, эрдэм шинжилгээний цогцолборыг түшиглэн "Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор" байгуулна.	89. "Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор" байгуулах	0%
1.3.1. Хангайн бүс - "Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс"	1.3.1.3. Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх, соёлын аяллыг хөгжүүлж, археологийн нөөцөд тулгуурласан "Төв Азийн түүх, соёлын голомт" соёлын аялал жуулчлалын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.	98. Архангай аймгийн Өгийнуур, Хотонт, Батцэнгэл, Ихтамир, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Хайрхан сумдын нутагт орших археологийн дурсгалд тулгуурласан цогцолбор байгуулах	0%
2.1.1. Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого	2.1.1.31. Залуучуудын боловсролын болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог дэмжих "Залуусын оролцоо хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.	220. "Залуусын оролцоо" хөтөлбөр хэрэгжүүлэх	0%
	2.1.1.32. Залуучуудад чиглэсэн спорт, соёл, урлагийн арга хэмжээнд соёлын бүтээгдэхүүн,	221. Соёл, спортын бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх, түгээх, түүнийг	0%

	үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг ашиглан оролцох боломжийг бүрдүүлнэ.	худалдан авах эрхийн бичгийг түгээх, ашиглах	
	2.1.1.34. Төрийн бүх шатны байгууллага залуу мэргэжилтнүүдийг дэмжих тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	223. Залуу мэргэжилтнүүдийг дэмжих тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх	0%
3.3.5. Дөрвөн улирлын аялал жуулчлал	3.3.5.7. Аялал жуулчлалын гол зам дагуу амрах өртөө, түр отоглох цэг, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулна.	889. Гол бүс нутгуудад аялал жуулчлалын цогцолбор байгуулах	0%
	3.3.5.8. Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг хөгжүүлж, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлнэ.	890. Үндэсний урлагийн их театрын шинэ барилга, Циркийн барилга, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театрын барилга, Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэлийн туршилт судалгааны лаборатори, Орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий үзэсгэлэнгийн павильон, Улсын драмын эрдмийн театр, Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын хүчитгэлийн ажлуудыг хийж гүйцэтгэх	0%
3.3.6. Соёл урлаг, соёлын өв уламжлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл	3.3.6.4. Түүхэн дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, "Соёлын биет өвийг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.	909. Үндэсний түүхэн болон уран барилгын дурсгалуудыг сэргээн засварлаж, боловсон хүчин бэлтгэх	0%
		910. Соёлын өвийг сэргээн засварлах төрөлжсөн лаборатори байгуулах	0%
	3.3.6.5. Соёлын биет болон биет бус өвийг эдийн засгийн эргэлтэд оруулах хатуу, зөөлөн дэд бүтэц, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	912. Соёлын биет бус өвийн үндэсний төвийг байгуулж, барилгыг ашиглалтад оруулах	0%
	3.3.6.6. Төв Азийн нүүдэлчдийн соёлын их наадмыг ЮНЕСКО-той хамтран зохион байгуулна.	914. Төв Азийн нүүдэлчдийн соёлын их наадмыг ЮНЕСКО-той хамтран зохион байгуулах	0%
	3.3.6.7. Гандантэгчэнлин хийд орчмыг "Далх, Тасганы дэнжийн Үндэсний соёлын өвийн дурсгалт газар" агуулгаар хөгжүүлж, "Буддын шашны соёлын өвийн цогцолбор" болгоно.	915. "Буддын шашны соёлын өвийн цогцолбор"-ыг байгуулах	0%
	3.3.6.8. Богд хааны ордон музейн орчмыг VIII Богд Жавзандамба хутагтын амьдарч ирсэн түүх, соёлд тулгуурлан төрөлжүүлж хөгжүүлнэ.	918. Богд хааны ордны орчмын түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах	0%
	3.3.6.9. Монгол кино үйлдвэр орчмыг монгол киноны түүх, соёлд тулгуурлан төрөлжүүлж хөгжүүлнэ.	919. Хүүхдэд зориулсан кино театрын барилга барьж байгуулах	0%

	3.3.6.14. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлтийн цахим шилжилтийн хүрээнд дэвшилтэт технологийг ашиглаж, "Цахим соёл II", "Соёлын эрхийн бичиг" системийг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	925. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлтийн цахим шилжилтийн хүрээнд дэвшилтэт технологийг ашиглаж, "Цахим соёл-II" арга хэмжээ хэрэгжүүлэх	25%
	3.3.6.15. Соёлын бүтээгдэхүүн, контент аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын салбарыг 1 тэрбум ам.долларын орлого бүхий салбар болгон хөгжүүлнэ.	927. "Go Mongolia" нэгдсэн брэндингийн доор Монгол Улсыг сурталчлах 4 улирлын аялал жуулчлалын контент бий болгох, олон улсын сувгаар түгээх	25%
4.4.1. Үндэсний эв нэгдэл	4.4.1.1. Монгол хүний бахархал, өв соёл, нүүдлийн соёлыг дэмжих үндэсний соёлын үнэт зүйлд суурилсан нийгмийн соён гэгээрлийн бодлого баримталж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлнэ.	1225. Үндэсний соёлын нэгдмэл байдлын судалгааг хийх	0%
	4.4.1.3. Монгол Улсын үндэсний эв нэгдэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс, аливаа талцал, хуваагдал, Үндсэн хуульт ёсны эсрэг үзэл, хандлага, гаднын зөөлөн хүчний бодлогын нөлөөнд орох эрсдэлээс хамгаалах, үндэсний эрх ашгийг нэгдүгээрт эрэмбэлэх ойлголт, хандлага, соёлыг нийгэмд төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1227. "Бүх нийтийн соёлын боловсрол хөтөлбөр-II" арга хэмжээг хэрэгжүүлэх	0%
4.4.2. Гадаад бодлого	4.4.2.7. Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг эх нутагт нь байршуулж, үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын баримтыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	1281. Баримтат өвийн бүртгэл, судалгаа, сургалт, хадгалалт, хамгаалалтын төв байгуулах	0%

Тайлант хугацаанд хэрэгжилтийн үр дүн хангалтгүй буюу 30-59%-ийн хэрэгжилттэй 10 арга хэмжээний жагсаалтыг тайланд хавсралтаар үзүүлэв.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/26 дугаар удирдамжийн дагуу хийсэн хяналт шалгалтаар Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан манай салбарын хариуцсан 89 заалтын 2025 оны хагас жилийн үр дүнг үнэлж 59 заалтыг “үр дүнгүй” гэсэн урьдчилсан үнэлгээ ирүүлсэн.

Иймд “үр дүнгүй” гэж үнэлэгдсэн 59 арга хэмжээний тайлагналын чанарыг сайжруулах үүднээс яамны газар, хэлтсийн холбогдох мэргэжилтэн, удирдлагатай хамтран ЗГХХГ-ын ажлын хэсэгт тайлбар гаргаж, нэмэлт мэдээлэл бэлтгэж Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/3348 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлж ажиллаж байгаа боловч, төсвийн тодотголоор хөтөлбөр арга хэмжээнд батлагдсан төсөв 68,509.7 сая төгрөгөөс 3.3 дахин хасагдсан тул зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байх гол шалтгаан болсон тухай дүгнэлт гаргасан.

3.2 Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний хөтөлбөрийн үр дүнг 13 шалгуур үзүүлэлтээр үнэлж байна. Нийт 13 шалгуур үзүүлэлтийн 2025 оны жилийн эцсийн хүрсэн түвшний гүйцэтгэл дунджаар 83.8 хувьтай байгаа бөгөөд 8 үзүүлэлт 100 хувь зорилтот түвшиндээ хүрсэн, 3 үзүүлэлт 60-84 хувь, 1 үзүүлэлт 30-59 хувь, төсөв хасагдсанаас судалгаа хийж тооцоолох боломжгүй 1 үзүүлэлт байна.

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
1. Спортын барилга байгууламжаас 15 минутын зайд амьдарч буй хүн ам	Хувь	2023	-	Суурь түвшнээс 1 хувиар нэмэгдүүлнэ.	0	0
2. Бүс нутгууд дахь аялал жуулчлалын бүтээгдэхүүн	Тоо	2023	5	10	6	60.0%
3. Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын нийт залуучуудад эзлэх хувь	Хувь	2023	40.3	40.3	31.3	77.6%
4. Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж	Хувь	2023	47.1	50	26.7	53.4%
5. Бүртгэлтэй соёлын өвийн нийт тоонд ашиглалт сайжирсан соёлын өв	Хувь	2023	19.3	20	21	100%
6. Бүртгэлтэй соёлын өвийн нийт тоонд оршин тогтнох чадварыг бэхжүүлсэн соёлын өв	Тоо	2023	14	15	15	100%
7. Бүртгэлтэй соёлын өвийн нийт тоонд хамгаалалтад орсон соёлын өв	Хувь	2023	34.8	35	35	100%
8. Монгол Улсын талаар цахим орчинд хийсэн хайлт	Тоо/сая	2023	150	400	396	99.0%
9. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн	Тоо	2023	5	8	8	100%
10. Олон улсын стандартын шаардлага хангасан үйлчилгээний байгууллага	Хувь	2023	16	20	20	100%
11. Үндэсний агуулгатай уран бүтээл	Тоо	2023	2500	2550	2555	100%

12. Соёлын үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд	Тоо	2023	5665	5700	5842	100%
13. Үндэсний бахархал, эв нэгдлийн индекс	Хувь	2023	90	91	93	100%
Нийт						83.8%

3.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт:

Сайдын буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг 5 шалгуур үзүүлэлтээр үнэлж байна. Нийт 5 шалгуур үзүүлэлтийн 2025 оны жилийн эцсийн хүрсэн түвшний гүйцэтгэл дунджаар 93.0 хувьтай байгаа бөгөөд 5 үзүүлэлт 100 хувь зорилтот түвшиндээ хүрсэн, 1 үзүүлэлт 30-59 хувьтай үнэлэгдэв.

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
1. Хүн амын бие бялдрын хөгжлийн индекс	Хувь	2023	76.2	76.2	70.7	100%
2. Нийт хүн амаас соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдсан иргэд	Хувь	2023	27.6	28	38.2	100%
3. Нүүдлийн соёл иргэншилт монгол зорилтын түвшин	Хувь	2023	36	37	74	100%
4.1. Хүлээн авсан жуулчид	Мянган хүн	2023	800	1400	820	58%
4.2 Аялал жуулчлалын салбарын орлого, ам.доллар	Тэрбум ам.доллар	2023	1.5	1.6	1,640	100%
5. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Хувь	2023	0.4	1	1.4	100%
Нийт						93.0%

Дөрөв. Дүгнэлт

4.1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хяналтад байгаа үндсэн хэрэгжүүлэх 83 арга хэмжээний хэрэгжилтэд журмын 6-д заасан аргачлалын дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 2025 оны жилийн үр дүнгээр 44 арга хэмжээ үр дүнтэй буюу 85-100 хувьтай, 9 арга хэмжээ үр дүн хүлээгдэж байгаа буюу 60-84 хувьтай, 10 арга хэмжээ үр дүн хангалтгүй буюу 30-59 хувьтай, 19 арга хэмжээ үр дүнгүй буюу 0-29 хувьтай, 1 арга хэмжээ хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэсэн үнэлгээ авч, дундаж үнэлгээ 66.5 хувийн үнэлгээтэй “Үр дүн хүлээгдэж байгаа” гэж дүгнэгдэв.

4.2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд батлагдсан хөтөлбөрийн үр дүнгийн 13 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ, 93.8 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн 5 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 93.0 хувьтай үнэлэгдэв.

4.3 Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 83 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхэд 300,215.3 сая

төгрөгийн төсөв шаардагдахаар төсөвлөсөн боловч 2025 оны улсын төсөвт 3 арга хэмжээнд 34,688.7 сая төгрөгийн хөрөнгө батлагдсан нь хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байх гол шалтгаан болж байна.

Тав. Зөвлөмж

“Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан яамны хяналтад байгаа 83 арга хэмжээний хэрэгжилтийг тавьсан зорилт, хүрэх түвшинд нь хүргэх зорилгоор гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн, дараах зөвлөмжийг яамны газар, хэлтсийн дарга нарт хүргүүлж байна. Үүнд:

1. Бодлогын баримт бичиг хоорондын уялдааг сайжруулах, өөрчлөх санал гаргаж, санхүүгийн нөөцийг оновчтой байдлаар хуваарилж, зохион байгуулалтыг сайжруулан, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай;

---oOo---